



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/48

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.4, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.6, 40.2, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны №04/41 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй Тэс петролиум ХХК-ийн 4 дүгээр байрны хойд талд байршилтай Шатахуун түгээх станцын зориулалтаар эзэмшсэн 0,5 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгон газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар эзэмших эрх нь хүчингүй болгосныг Тэс петролиум ХХК-д мэдэгдэж, холбогдох бичиг баримтыг нь хүлээж авахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2013 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ